
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн ... тоот тушаалын арван нэгдүгээр хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.14	Хуудасны тоо: 4
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан		Танилцах албан тушаалтнууд: Багш, ажилтан	

БАЙГУУЛЛАГЫН “ОНЫ ШИЛДЭГ БАГШ, АЖИЛТАН” ШАЛГАРУУЛЖ, ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: V1.2026

Түгээлт



Энэхүү журам нь манай сургуулийн өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ хурмыг батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

Зөвшөөрөл

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү хөтөлбөрийг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	
Боловсруулсан	Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан	Батбуян Буянжаргал	2026.01.07	
Хянасан	ДЧБСХААжилтан	Энх-Амгалан Шинэжаргал	2026.01.13	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.14	

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Хөтөлбөрийн өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт хөтөлбөрт орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ.Нийтлэг үндэслэл.....	1
ХОЁР.Шагналтныг шалгаруулах үзүүлэлт.....	2-3
ГУРАВ.Шагналд нэр дэвшүүлэх, шалгаруулах.....	2-3
ДӨРӨВ.“Оны шилдэг багш, ажилтан”-г шагнах.....	4
ТАВ.Бусад.....	4



Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өмнөговь аймгийн Политехник коллежийн үйл ажиллагааны болон улс, орон нутгийн нийгэм эдийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан багш, ажилтны хөдөлмөр, идэвх зүтгэл, санаачилга, ур чадварыг үнэлэх, урамшуулах, тэдний байгууллага болон улс, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил дэвшилд оруулсан хувь нэмэр үлгэр дуурайллыг олон нийтэд сурталчлан таниулахад байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан” шагналын зорилго оршино.

1.2.Өмнөговь аймгийн Политехник коллежийн “Оны шилдэг багш, ажилтан” шагнал нь тухайн жилд байгууллага болон улс, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн онцгой амжилт гаргасан журамж заасан шалгуур болзлыг хангасан багш, ажилтангаас шалгаруулан шагнаж урамшуулна.

1.3.Өмнөговь аймгийн Политехник коллежийн “Оны шилдэг багш, ажилтан” шагналаар жил бүр 7 багш, ажилтанг шалгаруулж шагнана.

1.4.Өмнөх оны байгууллагын шилдгээр шалгарч шагнагдаж байсан багш, ажилтан дараа оны шилдэг багш, ажилтнаар шалгарч шагнагдаж болно.

1.5.Өмнөговь аймгийн Политехник коллежийн “Оны шилдэг багш, ажилтан” шагналыг дараах төрлөөр шалгаруулна. Үүнд:

1.5.1.“Оны шилдэг мэргэжлийн багш”

1.5.2.“Оны шилдэг онолын багш”

1.5.3.“Оны шилдэг ажилтан”

1.5.4.“Оны шилдэг бүтээлч багш”

1.5.5.“Оны шилдэг залуу багш”

1.6.Өмнөговь аймгийн Политехник коллежийн “Оны шилдэг багш, ажилтан” шагналыг жил бүрийн шинэ жилийн баярын үйл ажиллагаан дээр гардуулна.



Хоёр.Шагналтныг шалгаруулах үзүүлэлт

2.1.“Оны шилдэг мэргэжлийн багш” шалгаруулах шалгуур:

- 2.1.1.улсад 5-аас доошгүй жил ажилласан, тухайн байгууллагад 3-аас дээш жил ажилласан байх;
- 2.1.2.байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан” шалгаруулах бүх шагналын шалгуур үзүүлэлтийг хангасан байх;
- 2.1.3.тухайн шагналд нэр дэвшүүлэх саналыг хамт олны 90-ээс дээш хувь нь дэмжсэн байх;
- 2.1.4.тухайн жилд өөрийн албан ажлын үр дүн, ур чадварыг 100 хувь үнэлүүлсэн байх;
- 2.1.5.сүүлийн 2 жилийн хугацаанд ёс зүйн доголдол гаргаагүй, сахилгын шийтгэл аваагүй байх;

2.2 “Оны шилдэг онолын багш”- шалгаруулах шалгуур. Үүнд:

- 2.2.1.тухайн байгууллагад 5-аас дээш жил ажилласан байх;
- 2.2.2.тухайн шагналд нэр дэвшүүлэх саналыг хамт олны 90-ээс дээш хувь нь дэмжсэн байх;
- 2.2.3.байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан” шалгаруулах бүх шагналын шалгуур үзүүлэлтийг хангасан байх;
- 2.2.4.сүүлийн 2 жилийн хугацаанд ёс-зүйн доголдол гаргаагүй, сахилгын шийтгэл аваагүй байх;

2.3.“Оны шилдэг ажилтан”- шалгаруулах шалгуур. Үүнд:

- 2.3.1.тухайн байгууллагад 3-аас дээш жил ажилласан байх;
- 2.3.2.тухайн шагналд нэр дэвшүүлэх саналыг хамт олны 90-ээс дээш хувь нь дэмжсэн байх;
- 2.3.3.байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан” шалгаруулах бүх шагналын шалгуур үзүүлэлтийг хангасан байх;



2.3.4.сүүлийн 2 жилийн хугацаанд ёс зүйн доголдол гаргаагүй, сахилгын шийтгэл аваагүй байх;

2.3.5.тухайн жилд өөрийн хариуцсан ажилдаа амжилт гаргасан байх;

2.4.“Оны шилдэг бүтээлч багш”- шалгаруулах шалгуур. Үүнд:

2.4.1.тухайн байгууллагад 5-аас дээш жил ажилласан байх;

2.4.2.тухайн шагналд нэр дэвшүүлэх саналыг хамт олны 90-ээс дээш хувь нь дэмжсэн байх;

2.4.3.байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан” шалгаруулах бүх шагналын шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

2.4.4.сүүлийн 2 жилийн хугацаанд ёс-зүйн доголдол гаргаагүй, сахилгын шийтгэл аваагүй байх;

2.4.5.тухайн жилд өөрийн хариуцсан ажилдаа амжилт гаргасан байх;

2.5.“Оны шилдэг залуу багш”- шалгаруулах шалгуур. Үүнд:

2.5.1.тухайн байгууллагад 2-оос дээш жил ажилласан байх;

2.5.2.тухайн шагналд нэр дэвшүүлэх саналыг хамт олны 90-ээс дээш хувь нь дэмжсэн байх;


2.5.3.сүүлийн 1 жилийн хугацаанд ёс зүйн доголдол гаргаагүй, сахилгын шийтгэл аваагүй байх;

2.5.4.тухайн жилд өөрийн хариуцсан ажилдаа амжилт гаргасан байх;

2.5.5.байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор шинэ санал, санаачлага дэвшүүлж, хэрэгжүүлсэн байх;

Гурав.Шагналд нэр дэвшүүлэх, шалгаруулах

3.1.“Оны шилдэг багш, ажилтан” шагналд нэр дэвшүүлэх саналыг шинэ оны эхний сард багтаан байгууллагын Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтанд гаргаж хүргүүлнэ.

 ОМНЯГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ	№ Ж-3-030 Байгууллагын “оны шилдэг багш, ажилтан” шалгаруулж, шагнаж урамшуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-14 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
--	---	---

3.2.“Оны шилдэг багш, ажилтан” шагналд байгууллагын нийт багш, ажилтан өөрийнхөө болон бусад багш, ажилтны нэрийг дэвшүүлж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

Дөрөв.“Оны шилдэг багш, ажилтан”-г шагнах

4.1.Байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан” шагналыг сар шинийн баяраар гардуулна.

4.2.“Оны шилдэг багш, ажилтан” шагналд оны шилдэг багш, ажилтан өргөмжлөл, дурсгалын зүйл дагалдана.

4.3.Байгууллагын “Оны шилдэг багш, ажилтан”-аар шалгарсан багш, ажилтныг үндсэн цалингийн хувиар болон бэлэн мөнгө, бараа материал, гадаад, дотоод аялал, амралтын эрхийн бичгээр шагнаж урамшуулж болно.

Тав.Бусад

5.1.Энэхүү журмын хэрэгжилтэд байгууллагын удирдлага, Дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтан, албадын менежерүүд болон Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан хяналт тавьж, биелэлтийг хангана.

5.2.Журмын хэрэгжилтийн талаар байгууллагын удирдлага, албан хаагчид тодорхой санал, хүсэлт гаргаж, журамд тодотгол хийж, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.3.Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэйд тооцно.